



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 01 өдөр

Дугаар

А/48

Мандалговь

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 29.2 дахь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 09 тоот тогтоолоор баталсан “Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мандал багийн нутаг дэвсгэрт нисэх онгоцны буудлын баруун талд 2000 м.кв (0.2 га) газрыг 2 иргэнд төмс, хүнсний ногоо тариалах зориулалтаар 15 жилийн хугацаатай хавсралтад заасны дагуу эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигчийн газрын гэрчилгээг олгож, газар эзэмших гэрээ байгуулж ажиллахыг газрын даамал (Л.Хулан)-д зөвшөөрсүгэй.

3. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч иргэнд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ